ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2026 оны 10 дугаар сарын 05-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-26
1. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд */Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***гурав дахь хэлэлцүүлэг/***	6-26

Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы Төсвийн байнгын хорооны 10 дугаар сарын 05-ны өдөр /Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 38 минутад Төрийн ордны "Жанжин Д.Сүхбаатар" танхимд эхлэв.

Томилолттой: Х.Булгантуяа, Д.Жаргалсайхан;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батбаяр, Х.Ганхуяг;
Тасалсан: Н.Алтанхуяг, Ж.Ганбаатар, Б.Түвшин.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд */Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***гурав дахь хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ч.Номин, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга В.Содномдаржаа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, мөн яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, Боловсролын зээлийн сангийн захирал П.Зохихсүрэн, Нийслэлийн Засаг даргын Нэг дүгээр орлогч Б.Мөнхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.14 дэх хэсэгт заасны дагуу нэгдсэн хуралдаанаас тодорхой

асуудлын хүрээнд чиглэл өгсөн саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Г.Ганбаатар, П.Ганзориг, Б.Мөнхсоёл, Да.Цогтбаатар, Л.Мөнхбаясгалан, Ч.Номин, С.Цэнгүүн, Б.Жаргалан, Ж.Баясгалан нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Сангийн сайд З.Мэндсайхан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ч.Номин, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Санжаадорж, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, Боловсролын зээлийн сангийн захирал П.Зохихсүрэн, Нийслэлийн Засаг даргын Нэг дүгээр орлогч Б.Мөнхбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.14 дэх хэсэгт “чиглэл өгсөн тодорхой асуудлаас бусад асуудлыг хөндөхийг хориглоно.” гэсний дагуу чиглэл өгсөн зарчмын зөрүүтэй саналыг томьёоллоор санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул төслийн хэлэлцүүлгийг санал хураалтаар үргэлжлүүлэв.

Н.Наранбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Ж.Галбадрах, О.Саранчулуун, С.Эрдэнэбат нарын гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь мах, гурил, хүнсний ногооны хангамжийг тогтворжуулахад олгох 150,000.0 сая төгрөгийн татаасыг 13,223.9 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын сайдын багц дахь Боловсролын зээлийн сангийн санхүүжилтийг 13,223.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн гаргасан, Эрчим хүчний сайдын төсвийн багц дахь эрчим хүчний салбарын их засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд тусгагдсан 92,700.0 сая төгрөгийг 4,206.8 сая төгрөгөөр бууруулж, Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд олгох амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээ 478.0 мянган төгрөгийг 122.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, амьжиргааны доод түвшинд хүргэж 600.0 мянган төгрөг болгоход зориулж /17241 хүн/ Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд олгох амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмжийг 4,206.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь мах, гурил, хүнсний ногооны хангамжийг тогтворжуулахад олгох 150.000,0 сая төгрөгийн татаасыг 8,839.2 сая төгрөгөөр бууруулж, Нийгмийн халамжийн бусад тэтгэвэр /ахмад настан, тэжээгч нь нас барсан 0-18 насны хүүхэд, өрх толгойлсон эх, эцэгт/-ийн хэмжээг 432.0 мянган төгрөгөөс 168.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, амьжиргааны доод түвшинд хүргэж 600.0 мянган төгрөг болгоход зориулж /26307 хүн/ Нийгмийн халамжийн бусад тэтгэвэр /ахмад настан, тэжээгч нь нас барсан 0-18 насны хүүхэд, өрх толгойлсон эх, эцэг/-ийн зардлыг 8,839.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн гаргасан, Эрчим хүчний сайдын төсвийн багц дахь эрчим хүчний салбарын их засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд тусгагдсан 92,700.0 сая төгрөгийг 9,640.4 сая төгрөгөөр бууруулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох нийгмийн халамжийн тэтгэвэр /Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, одой иргэн/-ийн хэмжээг 478.0 төгрөгийг 122.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, амьжиргааны доод түвшинд хүргэж 600.0 мянган төгрөг болгоход зориулж /39510 хүн/ хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох нийгмийн халамжийн тэтгэврийн зардлыг 9,640.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь мах, гурил, хүнсний ногооны хангамжийг тогтворжуулахад олгох 150.000.0 сая төгрөгийн татаасыг 7,064.6 сая төгрөгөөр бууруулж, асаргааны тэтгэмжийн хэмжээг 330.0 мянган төгрөгийг 40.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 370 мянган төгрөг болгоход зориулж /88307 хүн/ асаргааны тэтгэмжийн зардлыг 7,064.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, С.Цэнгүүн нарын гаргасан, Төсвийн төслийн тооцооллын 14-т тусгагдсан нийт төсвийн ерөнхийлөн захирагчдын байрны

түрээсийн зардлыг тодотголын төслөөр нэмэгдсэн дүн буюу 14,157.2 сая төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, С.Цэнгүүн нар үг хэлж, санал хураалт явуулаагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 20 минут үргэлжилж, 30 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 76.7 хувийн ирцтэйгээр 15 цаг 58 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ Э.СУВД-ЭРДЭНЭ

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Наранбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Төсвийн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 66,7 хувьтай бүрдсэн тул 2026 оны 10 сарын 05-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026 оны 08 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.14 дэх хэсэгт заасны дагуу тодорхой асуудлын хүрээнд дахин хэлэлцэх/

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг 2026 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.14 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн гурав дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах шаардлагатай гэж үзэн Төсвийн байнгын хороонд буцаасан.

Иймээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дээрх заалтын дагуу төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг дахин хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Баттөмөрийн Энхбаяр Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Тилеуханы Аубакир Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Чинбатын Номин Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Бадрахын Найдалаа Эрчим хүчний сайд, Бяруузаны Пүрэвдагва Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Бэгзсүрэнгийн Мөнх-Оргил Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны

Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төмөр-Очирын Ням-Очир Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Адьяасүрэнгийн Даваажаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Мянгаагийн Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Юрагийн Отгонбилэг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга, Жамбалын Энхтөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Гомбожавын Ариунбуян Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Басангийн Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Батжаргалын Цогтнаран Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Пүрэвийн Зохихсүрэн Боловсролын зээлийн сангийн захирал, Ваанчиг-Арслангийн Содномдаржаа Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга.

Нэгдсэн хуралдаанаас чиглэл болгосон тодорхой асуудлын хүрээнд Улсын Их Хурлын гишүүн Баясгалан, Батнайрамдал, Цэнгүүн, Жаргалан нарын гаргасан зарчмын саналуудаар дахин санал хураалт явагдана.

Нэгдсэн хуралдаанаас чиглэл өгсөн саналуудтай холбоотой асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Ганбаатар гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: 6 ийм санал гараад ирлээ. Нөгөө ХХААХҮ-ийн сайдын багцад байгаа нөгөө мах, гурил, хүнсний ногооны хангамжийг тогтворжуулах, ирэх хаврууддаас нөгөө энэ инфляцаас ч байдаг юм уу тодорхой түвшинд үнийн өсөлтийг л барих мөнгөнүүд чинь ингээд хуваагдах гэж байна шүү дээ. Өөр эх үүсвэр яг бас олдоогүй юу энэ Сангийн яам, манай ажлын хэсэг Улсын Их Хурлын Тамгын газар ажиллаад зөвхөн энэ яг иргэдийн амьдралд шууд нөлөөлж болох энэ хэсгээс нь буцаагаад авах нь хэр зөв юм бэ. Жишээ нь би энэ Батнайрамдал гишүүний гаргаж байгаа 3500 оюутны сургалтын төлбөрийг төлөх асуудлыг дэмжиж байгаа. Энэ төсөв батлагдаад тэр хүмүүс чинь үндсэндээ гэрээ байгуулчихсан байгаа байхгүй юу. Захиргааны ерөнхий хууль дээр 1 зарчим байдаг. Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим. Тэр оюутнууд чинь аль хэдийн өөрсдийгөө тэтгэлэгтэй ямар ч байсан одоо юу гэдэг юм, багш мэргэжлээр суралцаад төгсөх хүртлээ энэ тэтгэлгээ авах юм байна гээд бодож байтал энэ дээрээс нь хууль гаргаад зогсоож болохгүй. Тэгэхээр би энийг зарчмын хувьд дэмжиж байгаа.

Гэхдээ авч байгаа эх үүсвэр нь буцаад л яг нөгөө ард иргэдийн нуруун дээр өдөр тутмын карманд нь нөлөөлдөг энэ хүнсний бүтээгдэхүүний инфляцаас хамгаалж, энэ тогтвортой хангамжийг барья, нэмэгдүүлье гэсэн зүйлээсээ аваад өгчхөж байгаа нь ямар үр дагавар үүсэх вэ. Сүүлд нь Засгийн газар бас инфляц ч гэдэг юм уу, хүнсний бүтээгдэхүүний инфляц чинь 13 хувиас бүр дээшээ гарах гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ зүйлийн буруутан нь өөрөө сүүлдээ Улсын Их Хурал болох уу гэдэг зүйл ч бас яригдах юм биш үү. Тэгэхээр энэ эх үүсвэрүүдийг бас нэгнээс нь аваад нөгөөд нь авахдаа бас ямар шалгуураар авчхав. Өөр юмнаас авч болоогүй юу. Энийг л хариулах гээд байна. Тэгээд би тэр 3500 оюутнуудын төлбөрийг буюу багш чинь өөрөө хүрэлцээгүй байгаа. Энийг нэгэнт одоо шийдвэр нь гараад, тэтгэлгээ аваад явж байсан юмыг зам дундаас нь зогсож болохгүй. Энэ бол хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг зөрчиж байгаа учраас энийг буцааж тэр тэтгэлгийг нь шаардагдах 13 тэрбум төгрөгийг нь тусгаж өгөх ёстой. Гэхдээ энэ эх үүсвэр нь буруу байна, өөр зүйлээс авч болоогүй юу гэдэг зүйл дээр л байгаад байна.

Н.Наранбаатар: Хариулъя. Сангийн яам эх үүсвэртэй холбоотой асуулт асуусан. Хэн хариулах юм. Энэ чинь нөгөө мах ногооны хүнсний хангамжаас аваад тавихаар ороод ирчихсэн байгаа шүү дээ. Санал гаргасан гишүүн эх үүсвэрээ ингэж тавьж орж ирж байгаа шүү дээ. Бусад нь бол хасуулъя гэсэн төсвийн ерөнхийлөн захирагч нар байхгүй. Хариултыг яах вэ. Санал гаргасан Их хурлын гишүүн зарчмын зөрүүтэй саналаа гаргахдаа эх үүсвэрээ өөрөө тавиад оруулж ирсэн. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: 2026 оны тодотгол үндсэндээ эрүүл мэнд, боловсролын салбарын хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлж орж ирж байгаа. Тэгэхээр тодотгол дээр бид нар хөдөө аж ахуйн салбар мах, гурил, хүнсний ногооны хангамжийг тогтворжуулах зорилгоор тавьсан эх үүсвэрээс ингэж олон санал хураалтаар ингээд төсвийг нь багасгах гэж байна л даа. Инфляцад нөлөөлж байгаа 3 том зүйл бол мах, гурил, төмс, хүнсний ногоо байгаа юм. 1 хувийн инфляц нөлөөллөөр зөвхөн тэтгэврийн зардал дээр 30 тэрбум нэмэгддэг юм. Одоо инфляц 10 хувьтай гэхэд ирэх онд 300-аад тэрбум төгрөг зөвхөн тэтгэвэр дээр ачаалал болдог. Тэгэхээрээ Засгийн газар инфляцыг багасгах дотроосоо бид нар хамааралтай энэ мах, төмс, хүнсний ногооныхоо асуудлыг гурил, улаан буудайн асуудлаа иймэрхүү зохицуулалтаар бага зардлаар шийдье л гэж байгаа шийдэл шүү дээ. Гэтэл энийгээ зохицуулах энэ зохицуулалтыг нь багасгачихаар нөгөө инфляц дээр чинь хариу эффект нь их өндөр гарна шүү дээ. Тэгэхээр энэ улаан буудай, мах, төмс, хүнсний ногоон дээрээс хасахгүй байхыг би гишүүдээс хүсэж байна. Яагаад гэвэл ахиад 1 хувийн инфляцын өсөлт тэтгэвэр дээр зөвхөн тэтгэвэр гэхэд 30 тэрбум. Ингээд цалин дээр дандаа хуульчлагдсан, инфляцтай уялдуулаад инфляцын өсөлттэй холбоотой цалин, тэтгэвэр дандаа нэмэгдэж яваа, манай урсгал зардлууд. Тэгээд энэ маань өөрөө гүйцэгдэхгүй нийт төсвийн чинь 80-аад хувь нь урсгал зардал болчхоод байгаа гэдгийг бүгд сайн мэдэж байгаа. Тэгэхээр ингээд энэ тавигдсан бодлогын юмыг л өөрчлөхгүй байхыг л хүсэж байна даа.

Тэгээд боловсролын салбар бол 13 тэрбум дотроо зохицуулах хэмжээний салбар хоорондын, хөрөнгө оруулалтын, урсгал зардлын бололцоо байгаа шүү дээ. Одоо тариаланчид, ногоочид хүлээж байгаа байхгүй юу. Энэ чинь 100 мянган тонн улаан буудай авна. 12 мянган тонн төмс, хүнсний ногоо авна. 20 мянган тонн мах бэлдэнэ. Ингэж байж 2027 ондоо бид нар эдийн засагтаа, макро эдийн засагтаа инфляцын нөлөөллийг бууруулж орно шүү дээ. Гаднаас хамааралтай шатахуун, нефть бүтээгдэхүүн дээр бид нар яаж ч чадахгүй байна шүү дээ. Үүний цаана чинь нөгөө өрхийн орлого, өрхийн амьжиргаанд нөлөөлөөд явчихдаг. Тэгээд инфляц буюу төсвийн урсгал зардал чинь ахиад автоматаар хөдөлгөдөг. Ийм л ийм гинжин холбоонд ороод байгаа юм л даа.

Тэгээд энийг бага дээр нь зогсоох, саармагжуулах хүрээнд эх үүсвэр татаад, төсвийн захирагч нарын хөрөнгө оруулалт, урсгал зардлыг нь хасаж байгаад оруулж ирж байгаа зардал байхгүй юу. Төрийн албаны олон үйлчилгээний цаана зогсож байгаа юм. Гэтэл энэ бодлогыг нь ахиад ингээд саармагжуулаад, тал талаас нь зулгаагаад ингээд явахаар энэ бол тийм эргээд л хавар болдгоороо л болно. Өсөлт дээр яагаад Засгийн газар арга хэмжээ авсангүй вэ гэдэг асуудал яригдана шүү дээ. Засгийн газар юу хэлэх вэ гэхээр, бид арга хэмжээ авсныг Их Хурал санал гаргаад юмыг нь байхгүй болгосон гэж хэлэх үү. Ийм л үр дагавар нь тодорхой болно шүү дээ. Тэгэхээр энэ саналаа Батнайрамдал гишүүн ээ татаад авчхаач. Тэр салбар хариуцсан сайд нь дотроо зохицуулаад шийднэ биз дээ.

Н.Наранбаатар: Асуулт, санал хамт байгаа юм. Тодруулъя Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Энхбаяр сайд сая бас тодорхой хэлчихлээ шүү дээ. Энэ хүнсний бүтээгдэхүүний тогтворжуулахын цаана ямар эффектүүд гардаг, юунаас урьдчилан сэргийлж байгаа гэдэг зүйлийг тодорхой хэлчихлээ. Тийм учраас би энэ саналыг энэ боловсролын салбартай холбоотой энэ 13,2 тэрбум төгрөгийг яг энэ хүнсний бүтээгдэхүүний тогтворжуулалтаас биш тэр Өмнөговьд өгч байгаа эрчим хүчний тэр татаасаас буюу 50 тэрбумаас гаргачих нь зүйтэй. Ингээд явъя. Ийм саналуудыг би бас бас зарчмын зөрүүтэй санал гаргачихъя гэж бодож байна. Говийн бүсийн тэр эрчим хүчний асуудал дээр өөрөөр зохицуулалт хийж болно шүү дээ. Энэ чинь цаана нь 3500 оюутны асуудал. Хүнсний бүтээгдэхүүний ажил асуудал гэдэг чинь 2 сая гаруй нийслэлд амьдарч байгаа хүмүүсийн яг бодит асуудал шүү. Ахмадуудын асуудал шүү, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал шүү. Тэгэхээр энийг бас ..../минут дуусав/

Н.Наранбаатар: Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд. Энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор бид нар ер нь Үндсэн хууль зөрчөөд байна уу, үгүй юу. Одоо энэ төсвийн тодотгол чинь Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1.7-д улсын төсөв, түүний гүйцэтгэлийг тайланг батлах гээд одоо бид нарын энэ яриад байгаа, өнөөдөр яах вэ, зарчмын зөрүүтэй 6 асуудал орж ирж байна. Одоо энэ тодотголоор ярих нөгөө боловсролын салбарын дутагдсан 674,5 тэрбум төгрөг гээд энэ чинь бид нарыг батлаагүй байхад зарцуулчхаад, одоо тодотгол руу оруулах гээд байна. Би тэгж ойлгож байгаа буруу юу. Ер нь бол байж байгаарай. Би эхлээд яриадахъя Энхбаяр сайд аа.

1 дүгээрт бид нар ер нь Улсын Их Хуралаар өнгөрсөн жил зөвхөн багш, эмч нарын л гэж ярьсан шүү дээ. Ажилчид гэж төсөв дээр суугаагүй. Яах вэ ажилчдыг ялгаж байгаа юм биш. Гэхдээ энэ чинь нэгэнт Улсын Их Хурлаар баталчихсан бол Засгийн газар чинь хэрэгжүүлэх үүрэгтэй биз дээ.

2 дугаар асуудал энэ зарчмын зөрүүтэй 6 саналын тэр 6 дээр нь тэр төсвийн төслийн тооцооллын хавсралт гээд Жаргалан гишүүн, Цэнгүүн гишүүд зарчмын зөрүүтэй санал гаргасан юм байна л даа. Тэр 14,157.0 тэр түрээс гээд. Энэ чинь нөгөө бид нарын яриад байсан сая энэ сарын хугацаанд болсон ярианы чинь эх үүсвэр, нөгөө 50 тэрбумын асуудал чинь биз дээ. Яах вэ, манай бүлгийн гишүүдээс 2 зарчмын зөрүүтэй санал гарсан нь яасан гэхээр яах вэ, нөгөө түрээснийх нь асуудлыг эргэж хар харъя, бодъё л гэсэн л юм байна л даа. Тэгэхдээ энэ 50 тэрбум төгрөг гэрт ойр сургууль хөтөлбөр гээд Улсын Их Хурлаар төсөв нь батлагдаагүй байхад Сангийн яамныхан бас ярьж байсан шүү дээ. Одоо ингээд үйл ажиллагаа нь явчихсан. Сургуулиудад түрүүчээс нь ингээд хандчихсан. Нөгөө Ерөнхий сайдын завдсан асуудал биз дээ. Өөрийнхөө ээжийн ч билүү сургуульд энэ асуудал чинь явчихсан гэж байгаа шүү дээ. Ингээд Улсын Их Хурлаар батлагдаагүй байхад 1 дүгээрт батлагдаагүй төсвийн тухай, 2 дугаарт төсвийнхөө тодотголыг хийгээгүй байж яагаад ийм асуудлуудыг энэ Сангийн яам оруулж ирээд байгаа юм. Одоо энэ чинь 9 сард хичээл эхэлнэ. 9 сар, өнөөдөр чинь 10 сарын эх гарчихсан 10 сарын 5 биз дээ. Ингээд төсвийн хууль зөрчөөд батлагдаагүй төсвийг урьдчилаад зарцуулаад эс үйлдэхүй хийгээд яваад байх юм уу. Энэ дээр хэн хариулах уу.

Н.Наранбаатар: Энэ дээр Боловсролын яам хариулъя. Ажлын хэсэг хариулж болно. Энхбаяр сайд хариулчих.

Ж.Энхбаяр: Хуулийн зөрчил байхгүй. Засгийн газар хуулийн хугацаанд тодотголоо, дагасан хуулиа өргөн барьчихсан 1 дүгээрт.

1,4 их наядын л асуудал байгаа. 1 их наяд нь тэтгэвэр нэмнэ. Тэтгэврийн суурь реформоо хийнэ. Цалин, эмч, багш нарын цалинг нэмэгдүүлэх 1 их наяд.

2 дугаарт эрчим хүчинд 200 тэрбум. Эрчим хүчний засвар үйлчилгээ, өвөлжилтийн бэлтгэл байдал, дээрээс нь өндөр үнэтэй авч байгаа импортын эрчим хүчийг айл өрх, аж ахуйн нэгж дээр үүрүүлэхгүйн тулд зөрүүг нь улсын төсөв дээр ачаа өгч байгаа.

3 хүнсний нөөц. Инфляцтай холбоотойгоор гадаад орчны өөрчлөлттэй холбоотойгоор хариу арга хэмжээний хүрээнд 150 тэрбумаар 100 мянган тонн улаан буудай, 12,5 мянган тонн төмс, хүнсний ногоо, 20 мянган тонн мах бэлтгэх зорилтоор авч байгаа мөнгө.

50 тэрбум нь сургууль. Гэрт ойр сургууль буюу өнөөдөр сургуулийн ачааллууд нэлээн өндөр байгаа. Ингээд хүн амын төрөлттэй холбоотойгоор ойрын 3 жилийн дараа сургуулийн ачаалал буугаад эхэлнэ. Одоо түрүүчээсээ цэцэрлэгийн ор сулраад, цэцэрлэгийн ачаалал буураад эхэлж байна. Энэ юу вэ гэвэл ирэх онуудад сургуулийн ачаалал, бага, дунд сургуулийн ачаалал буурна. Иймд улсын төсвөөр сургууль нэмж барихаас илүү суларч байгаа тэр орон тоо орон, тэр цэцэрлэг болон бусад хувийн хэвшлийн сургуулиудын сул анги танхим дээр зардал тавиад 3 жил явах нь эдийн засгийн хувьд ач холбогдолтой. 1 сургууль шинээр барихад 250-аад багш, ажилтан нэмж байгаа байхгүй юу. Нөгөө бид нарын шүүмжилдэг төр данхайгаад байна гэдэг чинь төрийн үйлчилгээ нэмэхээс аргагүй болоод байдаг. Тэрнээс тойрч байгаа, зардал хэмнэж байгаа л энэ бодлого шүү дээ. Энэ 4 зүйл дээр байгаа хуулийн зөрчилгүй.

Харин 11 сарын 01-ээс бид нар багтаж батлахгүй бол цалин, тэтгэвэр бүх юм тавигдахгүй хойшлох буюу хуулийн зөрчил буюу тэгээд улс төрийн асуудал болж хувирах болов уу. Одоо нөгөө сургуулиуд чинь Ганбаатар гишүүн ээ, хүлээгээд сууж байгаа. Ямар ч байсан бодлого бол зөв байна. Манайх ашиглуулахад бэлэн байна гэдгээ хийгээд, хүүхдүүдээ авчихсан байж байдаг. Хэрвээ энэ дээр төсөв хасагдах юм бол энэ ажил байхгүй болно л гэсэн үг. Тэгээд буцаад нөгөө 3 ангитай сургууль, нөгөө хол явдаг сургууль руугаа хийгээд, ахиад түгжрэл болон бусад нийгмийн ачаалал үүсээд л явчихна. Тэр чинь бас ахиад л нөгөө улс төрийн асуудал болж хувирна шүү дээ. Тэгээд хамгийн бага зардалтайгаар л шийдэж байгаа асуудал байхгүй юу даа.

Н.Наранбаатар: Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Яах вэ, би Энхбаяр сайдын яриад байгаа зүйлийг ойлгож л байна л даа. Энэ төсвийн тодотголд ахмадын тэтгэврийн нэмэгдэл, цалин хөлс гээд. Тэгвэл надад 2 тоо хэлээд өгчих.

Нэгдүгээрх нь, сургуулиуд хүлээгдэж байгаа. Өнөөдөр сургуулиуд хүлээгдэж байх цаг мөн үү. Одоо чинь 10 сарын 5 болчхоод байж байна. Гэрт ойр сургууль гээд 50 тэрбум төгрөгийг тавиад ороод ирчихсэн. Хэрвээ тийм байсан бол энэ тодотголыг чинь аль 8 сард хийгээд, 09 сарын 01 гэхэд сургуулиуд энэ тодотголоороо энэ мөнгө төгрөгөө аваад явж байх байсан байхгүй юу. Тэгээд одоо тэгээд 1 сар гаран ингээд хүлээж байгаа гэсэн үг юм уу. Эсвэл Сангийн яамныхны ярьснаар сургуулиуд нь

хүүхдүүдээ авчхаад, одоо мөнгөө орж ирэхийг хүлээж байгаа юм уу. 1 дүгээр асуудал нь.

2 дахь асуудал нь тэр багш, эмч нарын цалин чинь хэлээд байна шүү дээ. Бид нар багш, эмч нарын цалингийн нэмэгдэл баталснаас ажилчдын гэж байгаагүй. Тэгээд ажилчдынхаа тэр зөрүү дээр яасан юм. Одоо яг 2 сарын дутагдал үүссэн байгаа юм уу. Эсвэл илүү олгочхоод одоо төсвийн тодотголоор та нар .../минут дуусав/

Н.Наранбаатар: 6.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Багш, эмч нарын цалингийн хувьд бол түрүүлээд зарцуулчихсан юм бол байхгүй. Улсын Их Хурал дээр бол өөрөө төсөв батлагдахдаа багш, ажилчдын цалинг 50 хувиар нэмнэ гэдэг ийм агуулгаар томьёолол нь ороод ирчихсэн. Яг эцсийн найруулга дээрээ тэгж орж байсан. Тэгээд ийм байдлаар нөгөө санал хураагдаад явчихсан. Тооцоолол нь болохоороо зөвхөн багш нарын цалин нэмэхээр ороод ирчихсэн. Тэгээд Их Хурлаас нөгөө тодорхой чиглэл нь өөрөө ороод ирчихсэн учраас яг тэр дагуу нь багш, ажилчдаа бүгдийг нь нэмээд явчихсан ийм л зүйл болсон.

Н.Наранбаатар: Ганзориг гишүүн асуулт асууя.

П.Ганзориг: Би энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой боловсролын зээлийн сангийн санхүүжилт болох 13 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нэмэгдүүлэх асуудлыг 1 дүгээрт дэмжиж байгаа гэдгээ илэрхийлье. Ер нь Монгол Улсын Засгийн газраас 2026 оныг Боловсролыг дэмжих жил болгож зарласан. 2026 оны төсвийн тодотгол, 2027 оны төсөв өргөн барихдаа эрүүл мэнд, боловсролынхоо салбарыг нэн тэргүүнд анхаарна гээд ингээд яваад байгаа. Гэсэн хэдий ч өнгөрсөн 7 хоногт Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороогоор энэ Засгийн газраас өргөн барихдаа дутуу өргөн барьсан асуудлыг Батнайрамдал, Галбадрах, Саранчулуун, Эрдэнэбат нарын гишүүд санаачлаад, зарчмын зөрүүтэй санал гаргаад оруулж ирээд, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороогоор дэмжигдсэн асуудал чуулган дээр унасан. Тэгэхээр энийг бид нар эргэж харж, өнөөдөр энийг оруулахгүй бол түрүүн ярьсанчлан 3500 оюутны сурч боловсрох эрх бас хязгаарлагдана. Цаашлаад 3500 айл өрхийн амьдрал ахуйд бас энэ төлбөр нь тодорхой хэмжээгээр дарамт үзүүлнэ. Өөрсдөө төлөх үүрэг хүлээнэ. Тийм учраас энэ асуудлыг бол дэмжээд оруулаад явах нь бол зүйтэй гэж бодож байна. Зүгээр эх үүсвэрээ ярихдаа бодвол санал гаргасан гишүүн нь энэ салбарынхаа тодорхой сайдтай яриа байлгүй дээ. Энэ Идэрбат гишүүн чинь Хөдөө аж ахуйн сайд биз дээ. Байгаа юм уу энд. Тэгэхээр энэ асуудал дээр бол боловсролд оруулж байгаа хөрөнгө оруулалтыг дэмжээд, нэмэгдүүлээд явах ёстой. Ер нь бол цаашдаа энэ боловсролын зээлийн сангийн санхүүжилтийн асуудлуудыг бол нэмэгдүүлж явахгүй бол зээлийн эргэн төлөлт өнгөрсөн хугацаанд зах замбараагүй явсан асуудал, Боловсролын зээлийн сангийн хулгай, танил талаараа авдаг зээлүүдийн асуудлаас болоод шинээр ингээд зээл аваад явж байгаа хүүхдүүдийн санхүүжилт гадаад, дотоодод сургуулиуд санхүүжилтүүд хүнд болчхоод байгааг бид нар анхаарах ёстой гэдгийг хэлье. Баярлалаа.

Н.Наранбаатар: Санал хэлчихлээ тийм үү. Мөнхсоёл гишүүн асуулт, санал.

Б.Мөнхсоёл: Гишүүд яг энэ бусад гишүүдийн гаргасан саналыг ерөнхийдөө дэмжиж байгаагаа хэлж байна шүү дээ. Энэ боловсролын зээлийн сан ч бай, Баясгалан гишүүний маань санал болгоод гаргаад байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ялангуяа 16 нас хүртэлх хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асран хамгаалах, тэгээд амьжиргааг нь дэмжиж тэтгэлэг олгох энэ тэр гэдгийг дэмжиж байгаа юм. Маш сайн дэмжиж байгаа. Зөв зүйтэй. Энэ хүмүүсийн ар гэрийн амьдрал, амьжиргаа бол асар чухал. Бас өртөг нь өсөөд байхад энэ олгогдож байгаа тэтгэмж нь бас инфляц, бусад эдийн засгийн байдлаа дагаад өсөхгүй байгаа дээр санал нэг байгаа юм.

Хамгийн гол нь эх үүсвэрийн асуудал байгаад байна шүү манайхан. Эх үүсвэрийн асуудал. Сая жишээлбэл Ганзориг гишүүн бас хэллээ шүү дээ. Эх үүсвэр дээр жишээлбэл эрчим хүчний салбарын тоног төхөөрөмж, их засварын зардлаас авчихаар 13 байна уу, 14 тэрбум нийтдээ гарахаар эх үүсвэрийг ярьж байгаа юм байна шүү дээ. Гишүүд энэ саналыг гаргахдаа яадаг вэ гэхээр төсөв харна. Төсвөө харж байгаад, би энийг өөрчилмөөр байна. Тэгэхдээ энэ өөрчилмөөр, зардал нэммээр байгаа зүйлээ энэ сайдын багцаас, энэ төсвийн ерөнхийлөн захирагчийнхаас авчихъя гээд нөгөө бүрэн мэдээлэлгүй явдаг байхгүй юу. Энэ асар хэцүү. Тэгэнгүүт нөгөө олон нийт маань сошиалаас мэдээлэл авна. Бүрэн нухацтай мэдээлэлгүй, тэгээд нөгөө сошиалын болсон, болоогүй дайн үүсгэнэ. Энэ дээр би бүр санаа зовоод, зориуд хэлж байгаа юм. Тэгэхээр юу вэ гэхээр энэ өвөл яах юм бүгдээрээ. Өвөл нөгөө цахилгаан тоггүй болно, тэг зогсолт болно, өвөл хүйтэрнэ, дулааны асуудал яах вэ гээд ингээд том асуудал байдаг. Тэгээд эрчим хүч чинь өөрөө бас эдийн засгийн суурь салбар байхгүй юу. Энэ суурь салбар гэдэг нь өөрөөр хэлэх юм бол энэ 3,3 сая, 4 сая хүмүүст бүгдэд нь хамаатай асуудал. Өрх гэртээ дулаан баймаар байна, тариф бас асуудалтай байна. Нэмэх хэцүү, нэмэхгүй хэцүү. Нэмэхээр бас нөгөө өрх айлуудынхаа эдийн засгийн ачаалалд өртөг болоод байдаг. Нэмэхгүй байх гэхээр нөгөө эрчим хүчний салбар чинь дампуурчих гээд, зогсчих гээд байдаг гээд ингээд бүх асуудлууд зэрэг ундраад байгаа.

Тэгэхээр бүгдээрээ дандаа яриад байгаа шүү дээ. Бүх зүйлээ эрэмбэлье. Тэгээд хамтдаа нэг өрөөнд сууж байгаад энэ засаг ялангуяа дотроо сайн яриад энэ төсвийнхөө хуваарилалтыг оновчтой сайн хиймээр байна. Тэгэхгүй бол түүхий ийм зүйлүүд яваад ингээд буруу, зөвгүй шийдвэр гаргаад, сошиалын юмны төлөө болчих вий гэдэг дээр би бас санаа зовоод байна шүү. Аль аль нь чухал асуудлууд байгаад байдаг. Тэгэхээр энэ дээр манай Сангийн яам, Сангийн сайд, Засгийн газар сайн ажилламаар байна л гэж хэлмээр байна шүү. Аль алийг нь дэмжээд байна. Тэгээд аль нэг талдаа кноп дарахаас өөр гарцгүй болно. Тэгээд дарсан нь муу, дараагүй нь сайн, дарсан .../минут дуусав/

Н.Наранбаатар: Үг хэлчхэв үү. Аубакир сайд.

Т.Аубакир: Өдрийн мэнд хүргэе та бүхэнд. Ганц нэг саналаа хэлье. Асуулт бол байхгүй. Сая Ж.Энхбаяр сайдын хэлж байгаа асуудалтай холбоотой эх үүсвэр 150 тэрбум төгрөгийг Засгийн газраас өргөн хэрэглээний барааны үнийг тогтворжуулах хүрээнд 150 тэрбум төгрөгт махны, төмс, хүнсний ногооны, гурилын гээд. Тэгээд энэ Засгийн газраас нийт тэтгэвэр авагчид буюу цалин, тэтгэвэр маань энэ үнийн өсөлтөд идэгдэхгүйн тулд хэд хэдэн арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа юм. Тэрний 1 нь саяын өргөн хэрэглээний барааны үнийг тогтворжуулах, нөөц бүрдүүлэх явдал байгаа юм л даа. Тэгэхгүй бол бид нар ингээд өргөн хэрэглээний барааныхаа үнэтэйгээ уралдаад л нэмээд байх юм бол энэ чинь хаана ч хүрч зогсохгүй зүйл болно шүү дээ. Тэгээд тэрэнд 150 тэрбум төгрөг тавьж өгсөн. 20 мянган тонн мах,

14, 15 мянган тонн төмс, хүнсний ногоо, гурилын нөөц гэдэг юм уу. Тэгээд энэ эх үүсвэрээс нь ингээд гишүүд өм цөм аваад тавьж байна л даа. Тэгээд энэ маань эргээд Засгийн газар өргөн хэрэглээний барааны саяын мах, хүнсний ногооны нөөц бүрдүүлж чадахгүй л гэсэн үг. ОУВС, бусад гадна, дотнын эдийн засагч экспертүүд зөвлөж байгаа шүү дээ. Танайд бол чөлөөт өрсөлдөөн гээд яг хэдхэн бараан дээр байх боломжгүй. Хэдхэн ченжүүдийн гарт төмс, хүнсний ногооны чинь үнэ байгаад байна. Энэ чинь Засгийн газар нөгөө үнийг бууруулахын тулд 1 механизмаа ажиллуулах ёстой. Махны үнэ өсөөд ирэхэд нь интервенц хийх махаа гаргах л ёстой байхгүй юу даа. Тэгээд энэ зардлаас нь ингээд хасаж байгаа юм.

Тэгээд Баясгалан гишүүн маань бас зарим зүйлээ дутуу ойлгосон уу. Тийм ээ. Энэ чинь Монгол Улсын төр Засгийн газар, Улсын Их Хурал үеийн үед, үе үеийн Засгийн газар энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүүгээ чиглэсэн арга хэмжээнүүдийг авдаг шүү дээ. 2027 оны улсын төсөвт бид нар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ авдаг тэтгэвэр, тэтгэмж, асаргааны зардлыг бүгдийг нь нэмэгдүүлж орж ирсэн. Жишээлбэл 2025 онд 397.500 төгрөг авдаг байсан бол 2027 онд 525.800 төгрөг авахаар тооцож оруулж ирсэн. Төсвийн төсөлд суулгачихсан явж байгаа. Тэгээд ингээд та бусад хүнд буруу ойлголт өгөөд байна л даа. Төр огт ерөөсөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ харж хандахгүй байна. Салбарын сайд нь мөнгөө харамлаж байна гэж. Энэ чинь та бид нар өнгөрсөн жил 2026 оны улсын төсвийг энэ 334 тоотод сууж байгаад л 30 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлээд л оруулсан шүү дээ. Дээрээс нь 8,6 хувийн инфляцын өсөлт. Энэ жилийн хувьд ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох нийгмийн халамжийн тэтгэвэр, байнгын асаргаа шаардлагатай 16 нас хүртэлх хүүхдийн асаргааны тэтгэмж, асаргааны тэтгэмж, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмж, асруулж байгаа иргэнд улирал болгон өгдөг тэтгэмж гээд бүгдийг нь нэмэгдүүлээд орж ирсэн шүү дээ. Тийм учраас ингээд хэдүүлээ 1 нэгэндээ буруу ойлголт өгөөд Баясгалан гишүүн ээ, одоо энд сууж байгаа Улсын Их Хурлын гишүүд, Жаргалан гишүүн, Цэнгүүн гишүүнээс авхуулаад л эдийн засагч нар сууж байгаа юм. Энэ хүмүүс санал өгөхөд аягүй хэцүү болчхож байгаа. .../минут дуусав/

Н.Наранбаатар: Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Төсвийн тодотгол хэлэлцэх гээд иргэдэд жоохон ээлтэй шийдвэр гаргах гээд явсан манай нөгөө эрх барьж байгаа улаан намын цагаан байрны дээрэмчдээс томилогдсон хэдэн сайд нар эмзэг гэж найгүй болчихсон байна. Бас дээрэнгүй гэж найгүй болсон байна. Та нарыг аргадаад, эсвэл та нарыг одоо та нараас айна гэж бол байхгүй шүү дээ. Та нар бүх юмны дарга биш жинхэнээсээ. Бямбацогт дарга намайг чуулган дээр хэлээд байгаа юм. Чи бүх юмны дарга болчихсон юм уу гээд. Засгийн газар чинь бүх юмны дарга биш байхгүй юу даа. Эд нар чинь шийдлүүдээ гаргаж ирээд ярьж байх ёстой хүмүүс байхгүй юу. Одоо ерөөсөө зах замбараагүй, бүгдээрээ ерөөсөө бараг л чи яасан муухай хардаг юм гээд ирж зодох нь холгүй хэдэн сайд нартай л байна. Тэгээд энэ удаа бол нэрийг нь хэлэхээ больё зүгээр. Урдах ажлаа хийх боломжийг нь олгоё.

Манай Боловсролын яам зүгээр жишээ аваад ярихад хамгийн том яам. Хамгийн хүнд сурталтай яам. Манай Баянхонгор аймгийн боловсролын салбартай холбоотой хэдэн тоног төхөөрөмжийн асуудалд тодруулга авъя гээд л 3, 4 сар болж байгаа юм. 1 ч хариу байхгүй. Энэ ажил төрөл рүүгээ анхаарч, ажлаа хиймээр байна. Зүгээр энэ хулгай зэлгий, худлаа ярьдаг юмаа жоохон багасгамаар байна. Мэдээлэл ирүүлбэл сайн байна Боловсролын яамныхан. Сая энэ өнгөрсөн хагас, бүтэн сайнд тойрогтоо очиж ажиллаад ирлээ. Өвөрхангай орлоо. Баянхонгор орлоо.

Ахмадуудтай уулзлаа. Жилийн өмнө төрийн өмчит ААН-үүдийн хулгайг цэгцлэх юм бол тэтгэвэр нэмэх боломж байна гээд яриад явж байсан. Энэ шийдэл чинь олдоод байх шиг байна. Үүнийхээ араас сайн яваарай гээд захиж байна. Ахмадуудаа хандаад хэлэхэд би сайн явна. Та бүгдийн намайг сонгосон итгэлийг зүтгэлээр нь хариулна. Тэтгэвэр нэмүүлэх энэ ажлаа дуустал явна гэдгээ бас давхар хэлье.

Тэгээд боловсролын зээлийн сантай холбоотой баахан хулгай байгаа. Боловсролын яам. Энэ чинь зээлээ төлүүлэх ёстой болохоос биш чөлөөлөх гээд асуудал явагдах ёсгүй байхгүй юу. Та нар зээлийг чөлөөлөх биш, төлүүлэх ёстой. 15,5 тэрбум байгаа. Тэгээд Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдийн, өөрсдийнх нь, эхнэрийнх нь, дүүгийнх нь гээд хамаарал бүхий 12 гишүүний зээл, зээлийн хүү төлөгдөөгүй 5,7 тэрбум байгаа. Тэгээд сая энд Мөнхбаясгалан гишүүн хайгаад явж байна. Энэ нөгөө тэтгэлэг авчихсан гээд байгаа хүүхдүүдийн мөнгөнийх нь эх үүсвэр хаана байна. Хаанаас олох юм бэ гээд бүр санаа нь зовчихсон явж байна шүү дээ. Боловсролын зээлийн сангийн хулгайчдынхаа зээлийг төлүүл. Төлүүлнэ гэж оруулж ир. Энэ хүмүүс чинь бүгдээрээ нэр төртэй, энд тэнд ажил төрөл хийгээд, энэ зээл байтугай мөнгөө төлөх хэмжээний хүмүүс явж байгаа. Тайлбар хэрэггүй. Ажлаа хий. Дарга аа 1 минут нэмээд авчихъя. Тэгэх үү.

Н.Наранбаатар: 1 минут нэмж өгье Цогтбаатар гишүүнд.

Да.Цогтбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад Баясгалан гишүүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмжтэй холбоотой шүү. Зайлуул их биш. Маш бага тэтгэмжийн нэмэгдлийн асуудлыг ярьж байгаа юм. 30 гаруй тэрбум. Би нөгөө нэр үсгийг нь бас буруу хэлээд байж магадгүй. Эх үүсвэрийг нь зааж өгөх гээд байгаа юм. Эх үүсвэрийнхээ хувьд бол Эрчим хүчний яам дээрээс Оюутолгойн тэр цахилгааны төлбөртэй холбоотой татаас 50 тэрбум төгрөг байгаа. Энэчээнээс тэр Баясгалан гишүүний хайгаад байгаа 30 гаруй тэрбум төгрөгийн асуудлыг бас шийдэх боломжтой гээд энэ нөгөө эх үүсвэрийг хэлж өгч байгаа байдлаар саналаа хэлж байгаа юм. Баярлалаа.

Н.Наранбаатар: Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Цогтбаатар гишүүнтэй санал нэг. Сайд нарын зан ааш тэнгэрт гарсан. Харанхуй шөнөөр явж хүн амьтан загнадаг болсон. Өөрсдийгөө Далай ламтай зүйрлэдэг болсон. Их пээдгэр болсон. Кармандаа гараа шаачхаад гишүүдийг загнаад явдаг ийм л болсон. Сэтгүүлч энэ тэрийг загнана. Тэгээд тодотгол, улсын төсвийн цагаар Ерөнхий сайдыг дагаад Японд очоод амарна. Одоо Боловсролын сайд хаана байгаа юм. Тэр Хүнс, хөдөө аж ахуйн сайд хаана байгаа юм. Яг одоо тариаланчдад, яг одоо малчдад нэг их хайртай болчихсон худлаа хүмүүс. Хүнсний бүтээгдэхүүний инфляц өснө, ард түмэн сүйрлээ гээд үгүй ээ, та нарын явуулж ирсэн бодлого биз дээ энэ чинь. Тэгээд одоо сайд нар нь хааччихсан юм. Ерөнхийлөгчийг дагаад алга болсон л байна шүү дээ. Энд багшийн сургуульд орсон 3500 хүүхдийн төлбөр үлдчихсэн. Энийг сайд нь хасаад хаясан. Үгүй ээ, энэ чинь багш бэлдэж байгаа шүү дээ. Багш. Монголын ирээдүйг бэлтгэх багш нараа 100 хувийн тэтгэлэгтэй сургуульд оруулна гэж амлаж Монголын төр оруулчхаад, одоо болохоор чадахгүй гээд хөөгөөд гаргах гэж байгаа юм уу. Тэгээд сайд нь байхгүй. Боловсролын сайд нь ирээдүйн Монголын ард түмнийг боловсруулах 3500 багшийн сургалтын төлбөрийг шийдэх гэж байхад байхгүй. Худлаа яриад алга болчихсон.

Дээрээс нь улсын төсөвт ороогүй мөнгийг сургууль түрээсэлнэ гэдгээр оруулчихсан. Одоо тэгээд хулгай нь илрэхээрээ өмнөөс бөөн юм яриад байгаа байхгүй юу. Энэ 3500 хүүхдийнхээ сургалтын төлбөрийг, энэ дутагдаж байгаа энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох 30 тэрбумыг төсөвтөө суулгаад батлуулчихсан бол ийм юм болохгүй байсан. Одоо өнөөдөр энэ танхимд нөгөө байх ёстой сайд нар нь байхгүй, зугаалаад явчихсан. Тэгээд загнаад байдаг, өмнөөс доромжилдог, даажигнадаг энэ байдлаа татвал таарна шүү дээ. Тэгээд одоо бүгдээрээ ард түмэнд хайртай, малчид баларлаа, хүнс тариаланчид хараад сууж байна. Тэгээд тэд нар нь бид нарын буруу юм уу. Өөрсдөө ажлаа хийж чадахгүй. Тэгэхээр байхгүй энэ сайд нарыг яах ёстой юм бэ. Тодотгол хийж байна. Төсөв хэлэлцэх гэж байна. Тэгээд айхгүй. Асуулт асууя гэхээр мэддэг хүн байхгүй.

Би ямар Цахим хөгжлийн сайдаас асуултай нь биш дээ. Багш нарын энэ боловсролын зээлийн сангийн мөнгө яасан бэ гээд. Энхбаяр сайд хажууд үглээд суугаад байх юм та. Харин ингээд тоглоом хийгээд байгаа байхгүй юу. Бараа болоод байж байна гээд. Одоо хэлэх үг алга даа.

Н.Наранбаатар: Хариулт авах уу. Боловсролын зээлийн сангийн мөнгө яагаад тавигдаагүй байж байгаад одоо тавьж байгаа юм бэ гээд. Боловсролын яам хариулах уу. 7 номер.

Т.Ням-Очир: Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ням-Очир байна. Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. 2025 онд 16,8 мянга орчим суралцагчид олгох 31,6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдоогүй. Тэгээд 2026 онд 2025 онд үүссэн өр төлбөрийг бол 2026 оны төсвөөр төлсөн байгаа. Үүнтэй холбоотойгоор Боловсролын зээлийн сан дээр бол нэлээдгүй өр төлбөр бол үүссэн. Гэхдээ бид нар бол 2027 онд дэлхийн шилдэг болон дотоодын их сургуульд суралцах 3000 орчим оюутан, тэтгэлэг, буцалтгүй тусламжийн зардлаар сурах 30 мянга гаруй оюутныхаа зардлыг бол 2027 оны төсөв дээр төлөвлөөд, төсвийн төсөлдөө тусгаад явж байгаа. Мөн 33,6 тэрбум төгрөгийг зээлийн эргэн төлөлтөөс бас зарцуулахаар ингэж төсөвлөсөн байгаа.

Н.Наранбаатар: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: 3500 хүүхдийн сургалтыг төлөх ёстой мөнгийг яачихсан юм та нар яг. 1 дүгээр асуулт. Бүр яг тодруулаад өгөөч. Энэ мөнгийг яагаад тавиагүй юм бэ.

Нөгөөдөх нь болохоор танай сайд хаачсан юм. Боловсролын сайд. Энд 3500 ирээдүйн багш нарын тухай би асуугаад байгаа юм л даа.

Н.Наранбаатар: 7 номер.

Т.Ням-Очир: Энх-Амгалан сайдын хувьд бол орон нутгийн томилолттой байгаа. Боловсролын зээлийн сангийн холбогдох дүрэм журмын дагуу энэ дүрэм журам дээр квот тогтоохоор ийм зохицуулалт байдаг. Үүний дагуу 2025 оны 07 сарын 01-ний 363, 2026 оны 02 сарын 28-ны 62 гээд Боловсролын сайдын тушаалуудаар Боловсролын зээлийн сангаар суралцах оюутнуудын квотыг тогтоосон байдаг. Үүнтэй холбоотойгоор энэ квотод хэдий гэрээ байгуулсан ч гэсэн энэ квот тогтоосон тушаалаар квотод багтаагүй оюутнуудын асуудал гарч ирсэн. Тэгээд нэгэнт гэрээ байгуулагдчихсан учраас квотод багтаагүй энэ оюутнуудын

асуудлыг төсвийн тодотгол дээр бас тусгах ийм санал гарч байгаа. Тэгээд зээлийн сангийн ..../минут дуусав/

Н.Наранбаатар: Нэмж хариулах юм байна. 7 номер.

П.Зохихсүрэн: Өдрийн мэнд боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын үүрэг гүйцэтгэгч Зохихсүрэн. Мөнхбаясгалан гишүүний асуултад тодруулга хэлье. 2025 онд төсвийн гүйцэтгэл 31,7 тэрбум дутуу байснаас үүдэлтэйгээр 2026 онд энэ мөнгийг нөхөж санхүүжүүлсэн. Үүнээс үүдэлтэй төсвийн дутагдал 1 асуудал байна.

Мөн 2025 онд төсөв батлагдахдаа 2026 оны төсвийн тухай хууль батлагдахдаа санхүүжилтийн эх үүсвэр ийм хязгаарлагдмал буюу одоо энэ 3500 оюутны тухай бол энэ батлагдсан төсөвт ер нь багтахгүй байхаар эх үүсвэр батлагдсан байсан гэсэн үг. Тэгэхээр 3500 оюутны төлбөрийг өөр зүйлд зарцуулсан биш анхнаасаа санхүүжилт маань ингээд дутуу буюу хязгаарлагдмал хэмжээтэй байсан гэсэн үг болж байгаа юм.

Нийтдээ Боловсролын зээлийн сан дээр 62,7 тэрбумын санхүүжилтийн эх үүсвэр дутагдалтай байгаа. Үүнээс 15 тэрбумыг өөрсдийн эх үүсвэр буюу зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэхээр байна. Одоогийн байдал ..../минут дуусав/*

Н.Наранбаатар: Номин гишүүн асуулт асууна.

Ч.Номин: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би асуулт асуух гэхээс илүү санал хэлэх гэсэн юм. Юун түрүүнд бас энд саналаа гаргаж байгаа гишүүдийнхээ саналд маш хүндэтгэлтэй хандаж байгаа гэдгээ тодорхойлж хэлье. Мөн үүнээс гадна Засгийн газар, Улсын Их Хурлын хооронд мэдээллээ тодорхой болгох, өгч байгаа мэдээллээ ойлгомжтой болгох шаардлагатай байгаа гэдгийг бол хүлээн зөвшөөрч байгаа. Би ингэж хэлээд ямар асуудал үүсээд байгааг бас тодорхой хэлье гэж бодож байна.

Цэнгүүн гишүүний өгсөн 7 санал байгаа. Нийтдээ 4,8 тэрбум төгрөгийн төсвийн таналт хийх, энэ нь төсвийн тодотгол дээр байгаа 13 дугаар хавсралт дээр байгаа санал байгаа. Энэ дээр гишүүн маань болохоор төсвийн хэмнэлт хийх байдлаар санал оруулсан боловч яг өнөөдрийн байдлаар ямар зүйл үүсээд байгаа вэ гэхээр энэ 4.8 тэрбумын 7 саналын бараг 3,7 нь аль хэдийн хэрэгжчихсэн буюу төсвөө бид нар зарцуулчихсан гэсэн үг.

Би өөрийнхөө яаман дээр тодотгоод хэлчихье. 5 дугаар санал байгаа. Манай яамны төсөл хэрэгжүүлэх нэгж маань нийтдээ 62 төсөл арга хэмжээг ухаалаг засаглалын хүрээнд хэрэгжүүлдэг. Үүний зарцуулалт нь 296 сая төгрөг байдаг бол үүнээс бид нар өнөөдөр 198 сая төгрөгийг аль хэдийн зарцуулчихсан ийм арга хэмжээ дээр нөгөө төсвийн тодотголоор орж ирж байгаа бөгөөд 10 сард орж ирж байгаа учраас аль хэдийн санхүүжилт нь гарчихсан зүйл дээр тодотгол хийгдэхээр орж ирж байгаа. Хэрвээ энэ хууль яг энэ чигээрээ батлагдах юм бол ямар зүйл гарч ирэх гээд байгаа вэ гэхээр өнөөдрийг хүртэл энэ хуулийн дагуу зарцуулалт хийсэн, санхүүжилтийг гаргасан бүх төрийн албан хаагч нар хууль зөрчсөн болох гээд байгаа. 1 дүгээрт.

2 дугаарт болохоор үргэлжлээд эдгээр төслүүд нь ямар нэгэн шинэ болон нэмэлт санхүүжилт ирж байгаа зүйл биш. Одоо яг тавигдчихсан байгаа дүнгээрээ

гол нь яаж байгаа вэ гэхээр Сангийн сайдын багц дээр бүхлээрээ тавигдсан байсан зүйл нь тодотгол дээр орж ирэхдээ яам яамааараа нөгөө гүйцэтгэлийнхээ хүрээнд тавигдаад ороод ирчихсэн нь үл ойлголцол үүсгээд байгаа зүйл гарч байгаа юм. Тэгэхээр Цэнгүүн гишүүн маань энийг ойлгож үзээд, нөхцөл байдлын хувьд бид нар магадгүй мэдээллээ дутуу өгсөн байх. Тэгэхээр гэхдээ өнөөдрийн байдлаар энэ 3,7 тэрбум нь гарчихсан учраас бид нар хэрвээ энэ тодотголыг хийгээд, энэ мөнгөн дүнгээр 4,8-ыг хасах юм бол төрийн албан хаагч нар хууль зөрчих гээд байна. Цаашлаад энэ тодотгосон дүнгээ бид нар буцааж цалин тавьсан ажилтан, албан хаагчдаасаа буцааж нэхэх шаардлага бараг үүсээд байна.

Хөгжлийн төслүүдийн хувьд бол ямар зүйл байдаг вэ гэхээр Монгол Улс хөгжлийн түншүүддээ үүрэг хүлээдэг буюу төслийн нэгжүүдийн зардлыг буюу төслийн нэгж дээр байгаа ажилтан, албан хаагчдын зардлыг Монгол талаасаа даах ёстой байдаг. Энэ төслийн нэгжүүдээр ихэвчлэн цалингийн зардал гардаг илүү өөр зүйлүүд бол байдаггүй гэдгийг бас тодотгоод хэлье. Тэгэхээр энэ дээр анхаарч үзээд өгөөч ээ гэдэг хүсэлт байна.

Н.Наранбаатар: Үг хэллээ. Цэнгүүн гишүүн үг хэлнэ.

С.Цэнгүүн: Сая Номин сайд их ноцтой мэдээлэл хэлж байна. Төсвийн тодотгол 2026 оны 08 сарын 20-нд өргөн баригдаад, одоо батлагдаагүй байгаа. Батлагдаагүй байгаа зүйлийг аль хэдийн зарцуулчихсан гэдгээ дөнгөж сая хэллээ шүү дээ. Энэ чинь өөрөө хууль зөрччихсөн байна шүү дээ та бүхэн маань. Энэ бол асар аймшигтай зүйл хийсэн байна гэдгээ нотолж хэлж байгаа юм. Яагаад би энийг ингэж хэлж байна вэ гэхээр энэ төсвийн тодотголын хавсралт 13 гээд энэчээ Сангийн яамныхан энийг боловсруулсан. Сангийн яамныхан энд алдаа гаргасан гэж ингэж хэлэх байна уу, ямар байна уу. Энэ өөрөө Улсын Их Хурлын гишүүд дээр ирсэн мэдээлэл. Энэ дээр 2026 оны төсөв байхгүй. Байхгүй шүү. Өмнө нь явж байсан төслүүд биш, нэмэлтээр бүтэн дүнгээр орж ирсэн байгаа. Тэрний хүрээнд Улсын Их Хурлын гишүүнийхээ бүрэн эрхийн дагуу урсгал зардлыг Ерөнхий сайд нэмэгдүүлэхгүй гэсний дагуу шинээр энэ 10, 11, 12 сард шинэ төслийн нэгж байгуулахгүй гэдэг зарчмыг баримталж, би энэ зарчмын зөрүүтэй саналуудыг гаргасан буюу өнөөдөр тодотгол батлагдаагүй байхад та бүхэн энийг зарцуулчихсан гээд явж байна гэдэг чинь өөрсдөө маш том хуулийн хариуцлагад орж байна гэдгээ бататгаад хэлчихлээ.

Өнөөдөр бид нар энэ урсгал зардлыг багасгаж яах гээд байгаа юм бэ гэхээр бид бүхэнд өнөөдөр ахиад 1 төслийн нэгж, төслийн дарга, ахиад 1 ийм хүмүүс хэрэгтэй биш. Төрийн алба хангалттай том байгаа. Бид нар энийг чинь хэмнэсэн мөнгөөрөө жишээ нь манай Баясгалан гишүүн тэнд хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ анхаарах хэрэгтэй байна гээд зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа. Энэ дарга нарт зарцуулах гэж байгаа мөнгөө хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ бид нар зарцуулах бололцоо нь байна. Өнөөдөр энийг ганцхан Цэнгүүн гишүүн гаргаад, ганцаараа энийг шийдээд яваад байгаа биш. Улсын Их Хурлын гишүүд нь шийдчихсэн шүү дээ. Тэгээд тийм байгаа юман дээр бусад гишүүдээрээ, сайд нараараа бүгдээрээ нийлээд над руу дайрахынхаа оронд Сангийн яаман дээр хавсралт 13-ыг хийсэн, энэ зүйлийг гаргаж ирсэн хүмүүстэйгээ та бүхэн засаг дотроо ярих хэрэгтэй. Яагаад гэвэл энэ зүйл чинь би хуулийн хүрээнд ажлаа хийж байгаа хүн.

Одоо энийг Наранбаатар Төсвийн байнгын хорооны дарга бас залруулж хэлмээр байна. Сэтгүүлч нарт мэдээлэл өгөхдөө Цэнгүүн гишүүн андуурсан байна.

Буруу гаргасан байна гээд байгаа юм. Үгүй. Тийм зүйл огт байхгүй. Яг хуулийн дагуу байсан. Та тэрийгээ бас микрофон дээр яг хариуцлагатайгаар хэлж өгнө үү.

Н.Наранбаатар: Номин гишүүн.

Ч.Номин: Цэнгүүн гишүүн ээ, хоёулаа жоохон буруу ойлголцчих шиг боллоо. 2026 оны төсөв дээр бол энэхүү санхүүжилт маань бүрэн тавигдчихсан байсан байхгүй юу. 1 ёсондоо төсвийн ерөнхийлөн захирагч болох Сангийн сайдын багц дээр бүх л дүнгээрээ тавигдчихсан байсан. 2026 оны тодотгол төсөв дээр орж ирэхдээ задраад илүү гүйцэтгэлээ танилцуулаад орж ирсэн. Таны авсан эксел дээр байгаа зүйлүүд бол гүйцэтгэл танилцуулж байгаа гүйцэтгэлээрээ хуваагдчихсан байгаа байдал нь байхгүй юу. Тэгэхээр 2026 оныхоо төсөвтэй төсвийн тодотголоо харьцуулах юм бол 2026 оны төсөв дээр тавигдчихсан төсөв. 2026 оны тодотгол дээрээ болохоор задлаад орж ирсэн ийм мэдээлэл байгаа. Түүнээс биш энэ чинь Төсвийн хуулийн дагуу төрийн албан хаагч нар үүргээ гүйцэтгэдэг. Тэгэхээр Төсвийн хуулийнхаа дагуу хэрэгжилт нь гараад явж байсан байгаа юм шүү. Тэгэхээр тэн дээр бол буруу ойлголт гарсан байна гэдгийг тодотгоод хэлчихье.

Н.Наранбаатар: Цэнгүүн гишүүн ээ, миний ярилцлагыг түрүүн та дурдлаа. Шинээр 2026 оны төсвийн тодотголд сая Номин гишүүний хэлдэг шиг шинэ зардал тавиагүй юм. Энэ 2026 оны төсөв батлахдаа угаасаа энэ төсвийг нь баталж өгөөд, хэрэгжээд явж байгаа юм байна лээ. Тэгээд зөвхөн бөөн байсныг нь салгаж тавьснаараа шинэ юм шиг харагдаад байгаа юм. Тийм учраас шинэ биш, гүйцэтгэл нь аль хэдийн явчихсан. Тэр гүйцэтгэл нь 2026 оны төсөв батлагдахдаа дотор нь ороод батлагдчихсан нийт дүнгээрээ. Тийм л юм байна лээ шүү. Тэгээд би буруу зөрүү ярьсан бол уучлаарай. Бас хүмүүст буруу ойлгогдохоор ярьчихсан байж магадгүй.

Цэнгүүн гишүүн тодруулъя.

С.Цэнгүүн: Тэгэхээр энэ миний харж байгаа хавсралт 1 ондоо гээд, цаана нь байгаа хавсралт 1 ондоо гээд ингэж яриад байгаа юм. Тэгэхээр бид нар Төсвийн тухай хуульд бас өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл өргөн барьсан байгаа. Бид нар яг ямар ямар мөнгийг 50 төгрөг байна уу, 50 тэрбум байна уу, бүгдийг нь задаргаатайгаар нь хардаг байх ёстой. Тийм задаргаа өнөөдөр байж байх юм бол өнөөдөр бүгдээрээ ийм нэг сонин утгагүй асуудал яриад байх шаардлагагүй. Яагаад тэрийг ярьж байна вэ гэхээр энэ надад ч гэлтгүй бүх Улсын Их Хурлын гишүүн дээр байгаа мэдээллийн хүрээнд би зарчмын зөрүүтэй саналынхаа үндэслэлийг мөн гаргаад, энэ өөрөө урсгал зардлыг нэмэгдүүлсэн дүн байна. 2026 оны улсын төсөвт байхгүй байна гэдгээ өгөөд, би Байнгын хороо дээр санал хураалгасан. Их Хурлын чуулган дээр бас санал хураалгасан. Санал хураалгахдаа Их Хурлын гишүүн үндэслэлээ тайлбарлаж бичдэг. Тэр тайлбарынх нь дагуу саналууд хураагдаад явж байгаа. Тэгэхээр энэ маань бол ямар ч хууль зөрчиж .../минут дуусав/

Н.Наранбаатар: Энхбаяр гишүүн.

Ж.Энхбаяр: Саяын асуудлыг би үргэлжлүүлэн хөндөх гэсэн юм.

1 дүгээрт Сангийн яаман дээр нийт гадаад зээлийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслийн нэгжүүдийн зардал Сангийн яаман дээр 1 багц байсан нь тодотголоор бүх яамнуудад салгаж өгч байгаа юм. Аль яаман дээр ямар төсөл хэрэгжиж байгааг Их Хурал бас хянах ёстой гэдэг үүднээс салбар салбарт нь

тодорхой болгосон асуудал. Тэрнээс 1 төгрөг ч нэмэгдээгүй. Энэ тодотголд орсон, тэгээд салгасан төслийг чинь 70, 80 хувь нь хэрэгжээд явчихсан.

2 дугаарт энэ дандаа олон улсын гэрээ хэлэлцээрүүд байхгүй юу. Одоо жишээлбэл санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр соёрхон батлах тухай гээд Улсын Их Хурал хууль гаргаж баталдаг юм. Хууль болгож. Тэгээд жишээ нь манай дээр 1 төсөл байгаа. Энэ бас яг үүгээр төслийн бүх зардал байхгүй болчхож байгаа юм. Энэ чинь Монгол Улс болон АХБ, Европын сэргээн босголтын банк, Ногоон хөгжлийн сангийн хүрээнд .../минут дуусав/

Н.Наранбаатар: Тодруулга 1 минут.

Ж.Энхбаяр: Монгол Улсын 18 аймагт хэрэгжих аймаг,, сумын хөгжлийн хөтөлбөр явж байгаа байхгүй юу. Ингээд хэрэгжээд явж байгаа хөтөлбөрүүд. Одоо Увс, Ховд, Баян-Өлгийгөөс хэрэгжээд явж байгаа. Удахгүй бусад 15 аймаг руу ингээд задарч байгаа хөтөлбөр байгаа юм. Тэгээд энэ чинь Монгол Улсын хууль болгоод батлаад, үүний дагуу Монгол Улсын хүлээх үүрэг байгаа байхгүй юу. Тэр хүлээх үүрэг маань саяын яриад байгаа энэ төслийн нэгжид оногдох цалин хөлсний асуудал. Тэгээд энэ нь байхгүй болчихоор бид нар 1 дүгээрт хууль зөрчих асуудал болно шүү дээ. Баталсан хуулиа зөрчинө. Дээрээс нь хэрэгжиж байгаа том олон улсын хөтөлбөр зогсох эрсдэл үүсэж байна.

Тэр алдааны асуудал дээр гишүүн ээ, бид нар засаг дотроо ярина. Яагаад ийм байдал өгсөн юм. Энийгээ дэлгэрэнгүй танилцуулахгүй яасан юм гэдэг хариуцлагын асуудлыг Засаг дотроо ярина. Тэгэхээр ямар нэгэн урсгал зардал нэмж байгаа зүйл биш гэдгийг би дахин нотолж хэлж байна. Энэ бол 2026 онд батлагдсан төсвийн хүрээнд нарийн харин бүр аль яаманд ямар төслийн нэгж ажиллаж байгааг тодорхой болгосон л ийм цогц бичилт..../минут дуусав/

Н.Наранбаатар: Түрүүн Цэнгүүн гишүүнийх дуусчихсан шүү дээ. Одоо Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Би өнөөдөр хэд хоног нэлээн хэл ам дагуулаад байсан эксел файлын асуудлыг дахиад хөндөх гэж байна. Тэгээд тухайн үед ямар асуудал гарсан бэ гэхээр энэ гэрт ойрхон сургууль гэдэг хөтөлбөрт энэ төсвийн тодотгол дээр нэмж 50 тэрбум төгрөг тавиад, тэгээд 1 файлын асуудал гарсан. Тэгэнгүүт тэр файл болохоор ерөөсөө үндсэн үйл ажиллагаатай бараг холбоогүй зүгээр ийм бэлтгэл ажлын файл байсан энэ тэр гэсэн яриануд явсан. Тэгээд тэгэнгүүт сая яг энэ гэрт ойр сургууль хөтөлбөртэй холбоотой түрээсийн 14 тэрбум төгрөгийн асуудлыг хөндөөд, тэгээд зарчмын зөрүүтэй санал гаргасны ар дээр үгүй ээ, энэ гэрт ойрд сургууль чинь ерөөсөө бүр хэрэгжээд, хүүхдүүд нь сургуульдаа орчихсон байгаа. Энэ түрээснийх нь гэрээ энэ тэр хийгдчихсэн байгаа гэдэг асуудал яриад эхлэх юм. Тэгээд тэр гэрт ойрд сургууль 50 тэрбумтай холбоотой яг тэр файлынх нь задаргааны дагуу энэ түрээсийн 13 тэрбум 879 сая төгрөг яг энэ эксел файлын чинь дагуу энэ задаргаа чинь гарсан байна шүү дээ. Тэгээд энэ түрээсийн зардал 4 сарын хугацаанд гээд тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийн зардал гээд нийлбэр дүнгээрээ ийм 13,8 тэрбум төгрөг аль хэдийн гэрээ хэлцлүүд нь хийгдчихсэн, аль хэдийн хүүхдүүд нь сурч байгаа гэсэн мэдээллийг одоо өгч байна шүү дээ. Тэгэхээр чинь тэр гэрт ойр сургуульд 50 тэрбум төгрөгийн задаргаа гэдэг тэр эксел файл дээр байсан бүх юмнууд чинь хийгдчихсэн байсан болж тарах гээд байна шүү дээ. Би зөв ойлгож байна уу, буруу ойлгож байна уу. Одоо энэ Боловсролын яамнаас хэн байна, Нийслэлээс хэн байна. Та нар ямар тайлбар өгөх вэ.

Тэгээд энэ түрээсийн зардал гэдэг ангиллыг нь ингээд хараад үзэхээр та нар ингээд энэ эксел файл дээрээ сургуулиудынх нь нэрийг нь нуугаад зөвхөн байршлаар нь тэгээд бүр ийм аягүй нарийн задаргаатай ийм тоонууд ингээд төсөвлөчихсөн байсан юм байна шүү дээ. Тухайлах юм бол 138 сая 800 мянган төгрөг энэ кино үйлдвэрт 694м2 талбай энэ тэр гээд. Тэгээд энэ метр квадрат талбайнуудыг чинь тооцоод үзэхэд энэ түрээсийн зардал нь болохлоор 50-60 мянган төгрөг метр квадратын үнэлгээ нь байна шүү дээ. Энэ чинь бас маш өндөр зах зээлийн үнэлгээ шүү дээ. Тэгэхээр одоо ерөөсөө бүр өөрсдийнхөө хувийн эзэмшлийн байшин, объектыг төрд өндөр үнээр түрээслүүлдэг ийм бизнес бий болгочхож байгаа юм уу гэж ойлгогдохоор байна. Тэгээд энэ тавилга, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийн зардал гэдэг энэ баганаа бас надад тайлбарлаж өгмөөр байна.

Тэгээд нийслэл бас яг ямар эрх, үүргийн хэмжээнд, ямар шийдвэрийн дагуу энэ гэрт ойр 50 тэрбум төгрөг энэ зардлаа гаргачихсан юм бэ гэдгээ бас яримаар байна. Ер нь бол Улсын Их Хурал энэ төсөв батлах онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлж чадахгүй хэмжээнд хүрчхээд байна шүү дээ. Тодотголоор орж ирж байгаа зүйл .../минут дуусав/

Н.Наранбаатар: Боловсролын яам нийслэл гээд. 7.

Т.Ням-Очир: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр эхлээд санхүүгийн жил, хичээлийн жил 2 хоорондоо ингээд зөрж явдаг. 9 сарын 1-ээс хичээлийн жил эхлээд, дараа жилийн 6 сарын 1 хүртэл үргэлжилдэг. Тэгэхээр бидэнд бол 9 сарын 1-ээс дараа жилийн 6 сарын 1 хүртэл 9-10 сар өөрийнхөө байр талбайг түрээслэх иргэн, аж ахуйн нэгж буюу тухайн ачаалал өндөртэй байршлууд дээр бид нар судалгаа тооцоогоо хийж, тооцооллуудаа гаргадаг. Ингэхдээ Баянзүрх дүүргийн ийн жишээлбэл 14 дүгээр хороон дээр байгаа сургууль 960 хүүхдийн хүчин чадалтай юм байна. Энд 6-18 насны хүүхдийн тоо нь 3000 давчихжээ. Тийм учраас энэ сургууль дээр гарцаа байхгүй зохицуулалт хийх ёстой учраас энд бид нар сургалтын зориулалтаар аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан сургалтын зориулалтаар ашиглах байр талбай хэрэгтэй байна гэдэг нээлттэй зар мэдээллээ байршуулаад, ингээд яг тэр 14 дүгээр хороонд тухайн байгаа сургуультай ойр байршилтай иргэн, аж ахуйн нэгж манай байрыг сургалтын зориулалтаар та бүхэн судалж үзээч гэдэг байдлаар ингэж саналаа ирүүлдэг. Ийм байдлаар бид нар тухайн оныхоо 4 сард судалгаа тооцооллуудаа хийгээд, ингээд 9 дүгээр сараас эхлээд энэ байр түрүүн Энхбаяр сайд хэлсэн. Энэ байран дээр бол хүүхдийн тоо буурчихжээ. Энийг цаашдаа түрээслэх шаардлагагүй боллоо, цуцалъя гэдэг мэдэгдлээ өгдөг. Цаашлаад энэ байршил дээр гарцаа байхгүй хүүхдүүд илүү гараад байгаа учраас нэмэлт байр хэрэгтэй байна гэдэг ийм судалгаа тооцоолол хийгддэг. Жил болгон ЕБС-ийн хүүхдийн тоо 20-30 мянгаар өсөж байгаа. Үүний 50-60 хувь нь нийслэл Улаанбаатар хот дээр туршиж байгаа юм. Тэгэхээр тийм эксел файл дээр бол энэ байршил дээр 300 хүүхдийн хүчин чадалтай талбай хэрэгтэй байна гээд бид нар зар мэдээллээ байршуулаад, сарын турш нээлттэй тавьж байгаад хүсэлтүүдээ хүлээж авдаг. Энэ жилийн хувьд хотхоны бага сургууль, төрөлжсөн ахлах сургууль гээд бид нар зүгээр хүртээмжийг шийдэхээсээ илүү нарийвчилсан зохион байгуулалт төлөвлөлтийг оруулж ирсэн. Тийм учраас цаашид зүгээр юу гэдэг юм, хичээл сургалтын зориулалтаар ашиглахаас илүүтэйгээр иж бүрэн тохижуулж, авч явах ийм зохицуулалтуудыг хийсэн учраас .... би тайлбарлаадахъя гишүүн ээ.

Хичээл сургалтын үйл ажиллагаа 9 сард эхэлдэг учраас бид нар дээрээс нь хичээлийн жилээр байгууллагуудтайгаа гэрээгээ хийж явдаг учраас 4 сард судалгаагаа гаргаад, зар мэдээллээ байршуулаад, ажлын хэсэг нэг бүрчлэн байгууллагуудаараа явж үзээд, танай байгууллага дээр бид нар хүүхдүүдээ хичээллүүлье гэдэг байдлаар мэдэгдэл юмнуудаа өгөөд гэрээ байгуулаад явж байгаа гэсэн үг.

Тэгэхдээ хичээлийн жилээрээ бид нар тухайн байгууллагын барилга байгууламжийг ашиглая гээд гэрээгээ байгуулчихсан байгаа. Хичээлийн жилээр.

Н.Наранбаатар: 5 номер. Нэр, албан тушаалаа хэлээрэй.

Б.Мөнхбат: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Нийслэлийн Засаг даргын орлогч Мөнхбат. Нийслэлээс бол энэ хотхоны бага сургууль, төрөлжсөн ахлах сургуультай холбоотой асуудлаар хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан хичээлийн хэрэглэл, тоног төхөөрөмжтэй холбоотой 8 тэрбум төгрөгийг иргэдийн хурлаар батлуулсан байсан. Үүнийгээ зохион байгуулалт хийгээд явсан. Одоо гүйцэтгэлээр 5,5 тэрбум төгрөгийн гүйцэтгэл олгочихсон байгаа. Энэ бол Боловсролын ерөнхий хуулийн дагуу, мөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд хуулийн хүрээнд шийдвэрлэсэн асуудал байгаа гэдгийг хариулъя.

2 дугаарт бас түрүүн хэд хэдэн сайд нар ярьчихлаа. Энэ төслүүдийн асуудал дээр төсөв хасагдсан асуудал байгаа. Энэ дээр бол нийслэлийн нэгдсэн төслийн удирдлагын нэгж дээр 797 сая төгрөг хасагдахаар зарчмын зөрүүтэй санал орж ирж байна. Энэ бол түрүүн тайлбарласнаар 2026 онд төсөв батлагдсан. Батлагдсан төсвийн хүрээнд тухайн төсөл маань үйл ажиллагаагаа хэрэгжүүлээд .../минут дуусав/

Н.Наранбаатар: 5 минут гүйцээж хариулъя.

Б.Мөнхбат: 797 сая төгрөгөөс өнөөдрийн байдлаар 618.7 сая төгрөг нь зарцуулагдчихсан. Өөрөөр хэлбэл тэр төсөлд ажиллаж байгаа хүмүүсийн цалин, урамшуулал нь авагдчихсан. Энэ мөнгийг хэрвээ 797 сая төгрөгийг хасвал одоо бид ажиллаж байгаа ажиллагсдынхаа цалин дээр акт тавих, нөхөн төлүүлэх гээд бусад асуудлууд үүснэ. Энэ маань бол нэгдсэн багцаараа батлагдаад, задраад, Нийслэлийн нэгдсэн төслийн удирдлагын газар дээр зохион байгуулагдаад явж байгаа. Уг төсөл нь бол АХБ-ны хүрээнд гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах чиглэлээр ажилладаг ийм төсөл байгаа.

Н.Наранбаатар: Тодруулъя Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Тэгэхээр гэрт ойрхон сургуулийн 50 тэрбум төгрөг нөгөө хэл амтай эксел файл дээр байсан задаргаануудын дагуу бүх гэрээнүүд хийгдээд, тэгээд үйл ажиллагаа нь яваад эхэлчихсэн гэж сая захиргааны албан тушаалтнууд маань хэллээ гэж ойлголоо.

Тэгээд Цэнгүүн гишүүн бид 2-ын хувьд энэ гэрт ойрхон сургуультай хамааралтай түрээсийн зардал гэдэг 14 тэрбум төгрөгийн асуудлаар зарчмын зөрүүтэй санал гаргаад, тэгээд энэ нь өнгөрсөн Баасан гаргийн нэгдсэн чуулганы хуралдаанаар бүх гишүүдийн саналаар дэмжигдсэн байгаа. Гэтэл энэ Төсвийн

байнгын хорооны энэ хурал дээр биднээс зөвшөөрөл авалгүйгээр энэ зарчмын зөрүүтэй саналаа татаж байгаа мэтээр ингээд шууд санал хураалгах юманд оруулаад ирчихсэн. Би бол тэрийг бас гайхаж байна. Надаас бол зөвшөөрөл бол аваагүй. Энэ санал хураалт явагдаад гишүүд дэмжсэн. Дэмжигдсэн санал байхгүй юу. Тэгэхээр яагаад гишүүний бүрэн эрхэд халдаад байна вэ гэдгийг .../минут дуусав/

Н.Наранбаатар: Сая чуулган дээр Их Хурлын дарга асуусан шүү дээ. Гишүүд өөрсдөө зөвшөөрч байна уу гээд. Тэгээд зөвшөөрч байна гээд Байнгын хороо руу. Тэгээд санал хураалт яваад, тэгээд олонхын саналаараа орж ирсэн шүү дээ. Дахиж хэлэлцэх саналтай байна гэж хүсэлт тавиад, тэгээд санал хурааж орж ирсэн. Би Байнгын хорооны даргын хувьд.

Баясгалан гишүүн.

Ж.Баясгалан: Манай нээх их хэлд ороод, сүрхий яриад байсан нөгөө сайд маань яачхав. Аубакир. Энэ чинь юуны сайдыг нь ойлгохоо байчихлаа. ХХАА ч юм шиг, эдийн засгийн ч юм шиг. Нөгөө хүний хөгжил, гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллынхаа асуудлын эсрэг Баясгалан гэж хүнтэй л тэмцэж байвал болоо юм шиг юм ярьж байгаад гараад явчих юм. Үгүй ээ, санал хураана. Санал хураалт дээр өөрийнхөө эсрэг санал өгдөг ийм сайд байдаг юм уу. Өөрийнхөө салбарын эсрэг. Үгүй ээ, Ерөнхий сайд нь чиглэл өгчхөөд байхад тэрнийхээ эсрэг ингээд яваад байдаг сайд байдаг юм уу. Энэ одоо яг ямар учиртай юм бэ. Энэ чинь сайдтайгаа яримаар байх юм. Үгүй ээ, ер нь тэгээд явж явж энэ хурал болохоор хэдхэн сайд орж ирдэг. Үеийн үед Энхбаяр сайд бол дандаа л орж ирдэг, муулуулсан ч, загнуулсан ч өөдөөс нь тайлбар тавиад л, яриад л, хэрэлдэхдээ хэрэлдээд л сууж байдаг. Үгүй ээ, сайдууд ингэмээр байна шүү дээ. Орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрөө энэ тэтгэмжийг нэмээд өгөөч гээд хүмүүсээр гарын үсэг цуглуулаад явж байна шүү дээ. Хөдөө. Үгүй ээ, тэгэхэд салбарынх нь сайд болохоор энэ бол ерөөсөө инфляц үүснэ, талх, гурил гэж ярьж байгаад гараад явчих юм. Энэ салбарын сайд дээр бол би хариуцлага тооцуулна шүү. Энэ дээр бол бүр үнэхээр хэлье.

Тэгээд энд байгаа сайд нартаа, гишүүддээ хэлэхэд тэр сошиалаар ингээд бас хэтэрхий явж байна. Энэ сошиалаар явж байгаа чинь миний юм биш. Энэ чинь бодитой л юм. 110 мянган өрхийн асуудал. Хүний асуудал байгаа юм. Бид нар өнөөдөр ашгүй ороод ирлээ нөгөө сайд маань. Энэ хүний асуудал шүү дээ. Айл, өрхийн асуудал. 110 мянган айл, өрхийн асуудал. 1 сая төгрөгийн цалинтай хүмүүсийн асуудал биш, 8 саяын цалинтай хүний асуудал ч биш. Энэ бол ерөөсөө 330, 478 мянган төгрөгийн тэтгэмжтэй хүмүүсийн асуудал. Би нэмчихсэн. Та тоогоо мэдэхгүй байна гэж яриад байна. Уучлаарай та тоогоо мэдэхгүй. Яагаад гэвэл 2026 онд та тэр тоог биш, би оруулж ирсэн юм. 2026 оны бичлэг дээр байгаа шүү Аубакир сайд аа. Та хэрвээ ичихгүй бол тэр бичлэгийг чинь гаргана шүү. Эсрэг санал өгч байгаа чинь. Сая тодотгол дээр ганцаараа гараад явж байгаа чинь байгаа шүү. Салбараа хамгаал. Би хүнийхээ хувьд ерөөсөө өөртэй чинь юу ч ярихгүй. Салбараа хамгаал. Тэнд чинь 110 мянган айл байгаа юм.

Тэгээд гишүүддээ, сайд нартаа хэлэхэд бас тэр төсөв рүү нь орсон асуудлууд байж магадгүй мэдээж. Гэхдээ энэ бол Улсын Их Хурлын гишүүнийхээ бүрэн эрх гэхээсээ илүү өнөө маргаашийн амьдралаа яаж гэж аргацааж байгаа тэр хаягдсан, хүний эрх нь зөрчигдсөн хүмүүсийн төлөө хийсэн юм байгаа юм шүү. Зөвөөр .../минут дуусав/

Н.Наранбаатар: Санал байна. Ж.Энхбаяр гишүүн.

Ж.Энхбаяр: Байнгын хорооны гишүүд ээ, бүгдээрээ ийм хуулийн зөрчил рүү л яг орж байна гэдгийг би анхааруулъя. Энэ Монгол Улсын хууль 2023 оны 07 сарын 07-нд Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр соёрхон батлах тухай Монгол Улс болон АХБ хооронд тэр өдөр байгуулсан аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалт хөтөлбөрийг санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газарт өргөн мэдүүлсэн. Соёрхон баталсугай. Монгол Улсын Их Хурлын дарга Занданшатар гээд хууль болсон юм. Энэ хууль маань хэрэгжээд явж байгаа. Энэ хэрэгжүүлэх Засгийн газрын хүлээсэн үүрэг нь тэр төслийн нэгжийг хариуцаж байгаа. Энэ АХБ, Европын сэргээн босголтын банк, Ногоон зээлийн санхүүжилт гээд олон улсын хөтөлбөрөө бид нар Монгол Улсын 18 аймагт хэрэгжиж байгаа хөтөлбөрөө сая ингээд буруу ойлголцлоос болоод л ингээд тас цохичихлоо л доо. Тэгэхээр энэ нь өөрөө хуулийн зөрчил рүү явчхаж байна. Их Хурал баталсан хуулиа гишүүний горимын саналаар зөрччихөж байгаа байхгүй юу. Зөрчих асуудал руу орж магадгүй болоод байна. Тэгээд энийг урьдчилан сэргийлээрэй. Хуулиа биелүүлэх нь чухал байна шүү.

2 дугаарт энэ ямар нэгэн шинэ урсгал зардал биш гэдгийг бол маш үндэслэлтэй тайлбарлалаа. Сангийн яаманд байсан 1 багцыг салбар салбарт нь хэрхэн хэрэгжиж байгааг тодорхой байх үүднээс л ингээд тэр бичсэн хүснэгт нь өөр хуудсанд ороод ирсэн нь л жоохон буруу мэдээлэл болчихлоо л доо. Тэгэхээр 1 төгрөгийн зардал нэмэгдээгүй. Энэ зардлын чинь 70, 80 хувь нь зарцуулагдчихсан явж байгаа. Ийм зүйл. Тэгээд тэр сахилга хариуцлагын асуудал байвал бид нар дотроо ярина. Засаг дотроо ярина. Гишүүд маань энэ дээр ингээд хууль зөрчсөн асуудал руу ороод, Их Хурлыгаа бүр хууль зөрчүүлээд ийм байдал үүснэ. Яагаад гэвэл Их Хурал баталсан хуулийг горимын санал гаргаад хүчингүй болгож болохгүй байхгүй юу. Энэ чинь Монгол Улсын олон улсад хүлээсэн гэрээ конвенцоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлж байгаа юм. Энийг Цэнгүүн гишүүн минь зөв ойлгоорой гэж би танд уриалж байна, хүсэж байна даа.

Н.Наранбаатар: Батжаргал гишүүн горимын санал.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Хэдүүлээ бас мэдээллийн зөрүү ч байгаад байх шиг байна. Ойлголтын юмнууд ч байгаад байх шиг байна. Олон талаас нь яриад байна. Тэгэхээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар Улсын Их Хурлын чуулган дээрээс гүйцээн боловсруулах чиглэл авчихсан асуудлынхаа хүрээнд л ярина. Хэдүүлээ өөр юм ярих боломжгүй байхгүй юу. Тэгээд энэ хүрээндээ ярья.

2 дугаарт 2 л асуудал шийдэх гэж энд орж ирсэн. 1 нь тэр Боловсролын зээлийн сантай холбоотой Багшийн их сургуулийн оюутнуудын зээлийн 13 тэрбум байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой 4 чиглэлээр 30 тэрбум төгрөгийн асуудал байгаа. Энэ хүрээндээ л юмаа ярья. Үгүй ээ, үгүй байж бай.

Тэр ярьсан ярианы хүрээнд манай ХХААХҮ-ийн сайд, Эрчим хүчний сайд нар бас жоохон тайван байж бай. Амьдрал өнөөдрөөр дуусчхаагүй байна. Энэ төсөв бол хэдхэн тоо тавьчхаад баталчихдаг тоо биш. 1 хавсралт нь зорилтот түвшинд тавьчихдаг байхгүй юу. Улаан буудай 100 мянган тонныг нөөцөлнө. Хүнсний ногоо 12 мянган тонныг нөөцөлнө. Мах 20 мянган тонныг нөөцөлнө гээд. Тэгэхээр зэрэг 150-аас нь одоо миний энд тооцож байгаагаар бол 30 орчим тэрбумыг авч байгаа юм байна. Тэгэхдээ бид хэд энэ үйл ажиллагааг дэмжиж явах ёстой ХАА-н корпорац

гэж байгууллага байгуулсан юм. Тэрнийхээ бололцоо боломж дээр тулгуурлаад жоохон юм гарч ирэх бололцоо байна уу гэдэг юмаа нарийсгаж үзье.

2 дугаарт бүр боломгүй бол 2027 оны өргөн барьчихсан төсөв дээр энэ зохицуулалтынх нь асуудлыг шийдэж өгье. 1 ийм юм яримаар байна.

2 дахь эрчим хүч яг ийм. Бас 10 хэдэн тэрбумын асуудал эрчим хүчний салбараас яаж байгаа юм байна. Үүнийг мөн судалж бүх юмнуудаа хэдүүлээ дахиж нягталж үзээд, дутагдаж байгаа юм байвал 2027 оны төсөв дээр зохицуулалтыг нь хийж өгье. Одоо энэ дуусдаггүй яриагаа зогсоогоод, ажлын хэсэг маань манай гишүүд маань тал бүрээсээ суугаад оруулаад ирчихсэн энэ 5 саналын томьёоллоор нь санал хураалтаа шууд хийчихье. Нэгийг нь бол манай зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүд маань бас үнэхээрийн энэ дэвшүүлж байгаа зорилт юмаа хангах үүднээс задалсан тоог нь юу яасан юм байна. Үүнийгээ бид санал хураалтаас татчихъя. Хэлэлцүүлгийн аль ч түвшинд татаж болдог учраас татчихъя гэсэн санаа гарах гээд байгаа юм уу гэж би ингэж ойлголоо шүү дээ. Ийм байдлаар ойлгоцгооё. Одоо хэдүүлээ ингээд санал хураалтдаа оръё гэсэн ийм би горимын санал гаргаж байна.

Н.Наранбаатар: Батжаргал гар дарга горимын санал гаргалаа. Тэгээд горимын саналаар санал хураах юм байна. Санал хураалтад бэлтгээрэй гишүүд. Горимын санал хэрвээ уначихвал үгээ хэлнэ. Явбал санал хураалт. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй. Гишүүд орж ирээрэй. Санал хураалт явах гээд байна. Даваасүрэн дарга орох юм байна. Санал хураалтдаа бэлтгэх юм байна. Сайнзориг гишүүн санал хураалтад бэлтгэх юм байна. Пүрэвдаваа гишүүн. Санал хураалт явуулъя горимын саналаар санал хураалт. Батболд гишүүн хаана байна. Санал хураалт явуулъя. Горимын саналаар санал хураалт. 56,5 хувиар санал дэмжигдсэн учраас одоо санал хураалтдаа оръё. Энэ чинь дахиад санал хураалт бэлдэх билүү. Одоо шууд саналын томьёоллыг уншъя.

Нэгдсэн хуралдаанаас чиглэл өгсөн дараах асуудлуудаар санал хураалт явуулна.

1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь мах, гурил, хүнсний ногооны хангамжийг тогтворжуулахад олгох 150,000.0 сая төгрөгийн татаасыг 13,223.9 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын сайдын багц дахь Боловсролын зээлийн сангийн санхүүжилтийг 13,223.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал, Галбадрах, Саранчулуун, Эрдэнэбат. Санал хураалт. Тийм дэг байхгүй. 56,5 хувиар дэмжигдлээ.

2.Эрчим хүчний сайдын төсвийн багц дахь эрчим хүчний салбарын их засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд тусгагдсан 92,700.0 сая төгрөгийг 4,206.8 сая төгрөгөөр бууруулж, Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд олгох амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээ 478.0 мянган төгрөгийг 122.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, амьжиргааны доод түвшинд хүргэж 600.0 мянган төгрөг болгоход зориулж /17241 хүн/ Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд олгох амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмжийг 4,206.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баясгалан. Санал хураалт. 69,6 хувиар дэмжигдлээ.

3.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь мах, гурил, хүнсний ногооны хангамжийг тогтворжуулахад олгох 150.000,0 сая төгрөгийн татаасыг 8,839.2 сая төгрөгөөр бууруулж, Нийгмийн халамжийн бусад тэтгэвэр, /ахмад настан, тэжээгч нь нас барсан 0-18 насны хүүхэд, өрх толгойлсон эх, эцэгт/-ийн хэмжээг 432.0 мянган төгрөгөөс 162.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, амьжиргааны доод түвшинд хүргэж 600.0 мянган төгрөг болгоход зориулж /26307 хүн/ Нийгмийн халамжийн бусад тэтгэвэр /ахмад настан, тэжээгч нь нас барсан 0-18 насны хүүхэд, өрх толгойлсон эх, эцэг/-ийн зардлыг 8,839.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал хураалт. Улсын Их Хурлын гишүүн Баясгалан. 65,2 хувиар дэмжигдлээ.

4.Эрчим хүчний сайдын төсвийн багц дахь эрчим хүчний салбарын их засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд тусгагдсан 92,700.0 сая төгрөгийг 9,640.4 сая төгрөгөөр бууруулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох нийгмийн халамжийн тэтгэвэр /Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, одой иргэн/-ийн хэмжээг 478.0 төгрөгийг 122.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, амьжиргааны доод түвшинд хүргэж 600.0 мянган төгрөг болгоход зориулж /39510 хүн/ хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох нийгмийн халамжийн тэтгэврийн зардлыг 9,640.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баясгалан. Санал хураалт. 69,6 хувиар дэмжигдлээ.

5.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь мах, гурил, хүнсний ногооны хангамжийг тогтворжуулахад олгох 150.000.0 сая төгрөгийн татаасыг 7,064.6 сая төгрөгөөр бууруулж, асаргааны тэтгэмжийн хэмжээг 330.0 мянган төгрөгийг 40.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 370 мянган төгрөг болгоход зориулж /88307 хүн/ асаргааны тэтгэмжийн зардлыг 7,064.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баясгалан. Санал хураалт. 73,9 хувиар дэмжигдлээ.

6.Төсвийн төслийн тооцооллын 14-т тусгагдсан нийт төсвийн ерөнхийлөн захирагчдын байрны түрээсийн зардлыг тодотголын төслөөр нэмэгдсэн дүн буюу 14,157.2 сая төгрөгөөр бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жаргалан, Цэнгүүн. Санал гаргасан гишүүд үг хэлье. Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Манай улсын боловсролын салбарын чанар хүртээмжийн асуудал бол байнга анхаарлын төвд байгаа. Тэгээд бид нар бол боловсролын салбарынхаа чанар хүртээмжид маш их анхаарах шаардлагатай. Нөгөө талаас ийм төсвийн зарцуулалтын ил тод байдал хамгаас чухал. Тэгээд энэ гэрт ойр сургуульд төсөвлөгдсөн 50 тэрбум төгрөгийн асуудал бол задаргаа нь ойлгомжгүй, дээрээс нь ийм ашиг сонирхлын зөрчил гарсан байж болзошгүй маш ийм мэдээллийн ойлгомжгүй байдалд энэ хэлэлцүүлэг явагдсан. Тийм ч учраас би Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд энэ асуудал дээр зарчмын зөрүүтэй санал гаргасан. Энэ зарчмын зөрүүтэй саналыг бол өнгөрсөн Баасан гаргийн нэгдсэн чуулганы хуралдаанаар гишүүд дэмжсэн байгаа.

Тэгээд одоо болохлоор энэ Байнгын хороон дээр бол энэ асуудал дээр санал хураах нь зохимжгүй гэж бодож байна. Яагаад вэ гэхээр дэмжээд ингээд явчихсан. Бид нар бол саналаа татъя гэсэн шийдвэр бол ерөөсөө гаргаагүй. Зүгээр энэ ташрамд юу хэлэхийг хүсэж байна вэ гэхээр би сая Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, холбогдох хүмүүстэй нь бас уулзлаа. Энэ гэрт ойрхон сургууль дээр тавигдсан энэ 50 тэрбум төгрөгийн асуудлыг бүр илүү нарийн нягталж, мэдээллүүдээ авч байгаад, тухайн байршлууд дээр очиж бас үзэж байгаад,

магадгүй дараагийн хэлэлцүүлэг дээр энэ асуудлыг бас дахиж хөндөх боломжтой гэж харж байгаа. Тийм учраас би бол зарчмын зөрүүтэй саналаа татахгүй. Тиймээс энэ асуудал дээр битгий санал хураагаарай гэж Байнгын хорооны даргаас хүсэх байна.

Н.Наранбаатар: Цэнгүүн гишүүн. Микрофонд хэлье.

С.Цэнгүүн: Жаргалан гишүүн бид 2 адилхан 1 зүйл дээр 2 санал гаргасан байгаа. Тэгэхээр Жаргалан гишүүний саналтай адилхан гэсэн үг.

Н.Наранбаатар: Тэгвэл зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүд нь өөрсдөө санал хураалгахгүй гэж байгаа учраас санал хураалгах боломжгүй байна.

Нэгдсэн хуралдаанаас буцаасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар танилцуулна.

Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Байнгын хорооны гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

15.58 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ *Э.СУВД-ЭРДЭНЭ*